

БОГД ХААНТ ЗАСАГ БА 1913 ОНЫ ӨВӨРМОНГОЛЫН БАЙЛДААН

*Ө.Тайван**

Олон мянган жилийн төрийн баялаг түүхтэй Монгол оронд авч хэлвэл 1206 он ба 1911 онд болсон энэ хоёр хэргээс давах их зүйл байхгүй. Тэр нь монголчуудын эртний ба эдүгээд холбогдон түүхийн бүх явцад яруу тод хоёр чин баримтлал болон үүрд тэмдэглэгджээ. 1206 оны Монголын эзэнт гүрэн ба 1911 оны Богд хаант Монгол улсын аль нь ч гэсэн “Их Монгол улс”-ын утга бүхий улс төрийн өрнөлтийн үеийг бүрэлдүүлж монголчууд ба тэдний түүхэнд хүчтэй нөлөөлсөн билээ. Гэхдээ бид 1911 оны учрыг нягтлан үзэхийг зорьж орчин үеийн монгол үндэстний эрх чөлөөний хөдөлгөөнд Өвөр Монголын гаргасан үйлдэл нөлөөг үнэн зөвөөр нь үнэлэн Өвөр Монгол орны нийгмийн хувьслын түүхийн нэг хэсгийг сэргээн босгох нь судалгааны их чухал сэдэв юм.

1911 оны Монголын цагаагчин гахай жилийн хувьсгалын үр дүнд нэгэнт байгуулагдсан Богд хааны засгийн газар нь Ар, Өвөр Монголыг нэгэн улс гэрт нэгтгэх зорилготой байжээ. Энэ нь тэр үеийн улс дорнодын улсын хоорондын харилцаан дахь нэгэн төвөгтэй асуудал болж их хөл үймээн дэгджээ. Өгүүлэн буй үед болсон Монголын Богд хааны засгийн газар болон Бээжин дэх Юань Шикайн засгийн газрын хоорондох зөрчил мөргөлдөөн ялангуяа Өвөр Монголын асуудлаас болж тэдний хоорондох зөрчил хурцдаж байснаа эцэстээ 1913 оны Өвөр Монголын байлдаан үүссэн.

Уг байлдааны явц холбогдох учрууд хийгээд түүнд оролцсон чухал хүмүүсийн хөргийг түүхчлэн бичих хэрэгтэй. Энэхүү хэрэг хувьслын түүхт ахуйг тодорхойлоход тухайн үеийн Богд хааны засгийн газарт тулгарсан гадаад, дотоодын улс төрийн байдал жич Богд хаант улсын хэлбэрээр сэргэж байсан Монголын төр ба Өвөр Монгол орон лугаа Өвөр Монголтой харьцааг нягтлахын дагуу Монголын асуудалд авсан Чин улс, иргэн улс, Орос, Япон зэрэг улс төрийн хүчний талын арга бодлогуудыг ялгаруулан дүгнэх үгүй байж болохгүй.

Юуны өмнө эцсийн нэг тайлагч Вант төр хэмээгдэх Чин улсын үеийн Монголын нийгмийн хувьсалын явцыг анхаарах хэрэгтэй. Манж чингийн ноёрхлын үеийн монголын түүхийг нягтлахдаа бид Б.Я.Владиморцовын “Монголын нийгмийн байгууллын түүх”-д дурдагдсан нэг зүйлийг санах хэрэгтэй. Үүнд “Монголын олон аймгууд оновчтой шиг яривал Монголын феодалын уялдал цогцын ихэнх хэсгийг дайлан дагуулсан манж нь үндсэндээ тэдний нийгмийн зохион байгуулалтыг эвдсэн үгүй юм” гэжээ. Түүхийн энэхүү өвөрмөц нөхцөлд шарын шашин монголчуудын оюун санаанд шингэж

* Ө.Тайван - Өвөр Монголын Их сургууль

тэдний угсаатны адилшил болж бүрэлдэн Монгол орон ч хошуу засгийн эрх мэдэлд хамгаалагдаж байжээ. Өөрөөр хэлбэл 17-р зуунд монголчууд дайчин гүрний ноёрхолд орсноос аваад үндэстэн угсаа улмаар доройтон байсан ч Монголын нийгмийн дотоод бүтцэд онц их самуурал гаргасангүй.

Гэвч 18-р зуунаас хойш ялангуяа 19-р зууны сүүлийн үед хятадчуудын их хэмжээний умарш нүүдэллэн Монгол оронд орсон нь Монголын уул нийгмийн дэглэмд их хувиралт үүсгэжээ. 19-р зууны сүүлч 20-р зууны эхээр монголчуудын аж амьдрал улам уруудан Монголын нийгмийн ороо бусгаа тайван бус цаг эринд татагдан оров. Монгол газрыг тариан иргэдээр дүүргэж нүсэр их албан татварыг чангалан үржил шимтэй нутаг бэлчээрийг нь булаан авах Манжийн засгийн шинэ бодлого монголчуудыг цаашид хүлцэхийн аргагүй болгов.

Энэхүү түүхт цаг үед Монгол орны үндэстэний зөрчил өдөр ирэхүйеэ хурцдан хошуу нутгийн монголчууд өөрсдийн оршин тогтнох эрх мэдлээ хамгаалахын төлөө Манж чингийн колони дэглэмийн эсрэг босч тэмцсээр байв. Монголын олон газарт өргөн хөгжсөн атар хагалбарлахыг эсэргүүцсэн зэвсэгт бослого нь Монголын ард түмний өргөн давхаргыг хамран Ар, Өвөр Монголын эл этгээдийг донсолгожээ.

Энэ үед Өвөр Монгол орноор нэгэнтээ нийгмийн улс төрийн шинэ хүчин ба хувьсал хөгжлийн элемент буй болж байсан юм. Тогтох, Гүнсанноров, Хайсан, Дамдинсүрэн, Одой, Бавуужав, Гончигсүрэн, Насанарбижих мэтийн үндэстэний хямралдаанд ороогдсон Өвөр Монголын ван гүн, сэхээтэн ба бослогын удирдагчид нь үндэсний эрх чөлөөний замыг сүвэгчлэн хайж байсан юм. Тэд нар хүсэл эрмэлзлээ Ар Монголд тавьж Чин улсаас ангижрах ажиллагаагаа аль хэдийн цагаачин гахай жилийн хувьсгалын өмнө үеэс явуулж байсан юм. Үндэсний эрх чөлөөний төлөө боссон өвөр монголчууд их хүрээ зорьж тэмцэж байсан нь тэр үеийн нэг томоохон хандлага болох юм. Халхын газар нутаг нь орчин үеийн үндэстний эрх чөлөө, тусгаар тогтнолын хөдөлгөөний төв голомт болсон нь зүүнш Халх голын тэртээгээс аваад баруунш Алтай уулын нуруу тулсан энэ газар нутаг эрт үеэсээ ар, өвөр монголчуудын аж ахуй соёл шашны төв байсан түүхтэй уялдаа холбоотой билээ.

Иймээс Халхын нутаг нь Өвөр Монголын монголчуудын хувьд хүсэл мөрөөдөл төдий боловч бэрх зовлонтой үе бүрдээ ар газрыг зорьж явах сэтгэлгээ нь ер арилсан үгүй юм. Өвөр Монголчуудад авч хэлбэл ар газар гэгч амгалангийн орны билэг тэмдэг байсан билээ. Өвөр Монголын Жирмийн чуулганы Жалайд хошуунд 1905 онд лам нараар удирдуулсан ардын хөдөлгөөн гарчээ. Тус хөдөлгөөн нь хэрвээ тус хошууны худалдагдсан газрыг буцааж өгөхгүй юм бол Их Хүрээний зүг чөлөөт нутаг руу нүүдэллэнэ гэсэн урианы дор явагдсан юм. 1905 оны намар мөн Жирмийн чуулганы өмнөд Горлос хошуунд Тогтох тайж (1863-1922)-ийн

удирдлагаар ардын зэвсэгт бослого гарчээ. Бослогод оролцогсад Манж чин улсын колончлох бодлогын эсрэг Монгол орныхоо эрх чөлөө тусгаар тогтнолын төлөө тэмцсэн юм. Тэд хятадын шунахай худалдаачид мөнгө хүүлэгчдийн пүүсийг эвдэн сүйтгэж өрийн дансийг шатаан устгаж олзолсон эд хөрөнгө мөнгийг нутгийн ядуу ардуудад тараан өгсөн билээ. 1905-1910 оны завсар Тогтохын цэрэг хятадын цэрэгтэй олон удаа дайтжээ.

Тогтохын бослого нь Өвөр Монголд үндэстний эрх чөлөөний хөдөлгөөн шинээр өрнөхөд хүчтэй нөлөө үзүүлжээ. Өвөр Монголын олон нутгаар колончлох бодлогыг эсэргүүцсэн тэмцэл үүсч байдал улмаар хурцдан байсан бөгөөд тэр үеэр өвөр чуулгануудаас монголчууд бөөн бөөнөөр Ар Монголд нүүх явдал эхэлсэн билээ. Өвөр Монголд болсон бослогууд хэдийгээр удаа дараалан дарагдаж байсан боловч доромжлол дарлалын эсрэг боссон хөдөлгөөн нийт монгол үндэстний эрх мэдэл тусгаар тогтнолын тэмцэл болон нэгдэх замаар өргөжсөөр байв. Энэхүү Монгол орны нийгмийн донслолтыг дагалдан монголчууд түүхийн шинэ эргэлтийг олж харав. 1911 онд дотор газар цагагчин гахай жилийн хувьсгал дэгдэж Манж чингийн ноёрхол нурж эхлэв.

Түүхт энэ шинэ нөхцөл дор монголчууд эрх чөлөөний түүхт шаардлагаа дурьдан гаргав. 1911 онд үндэстний тусгаар тогтнолоо сэргээж шинэ тулгар Монгол улс байгуулагдсаныг тунхаглажээ. Халх Монголд Богд хааны засгийн газар байгуулагдав. Дээр дурьдсан зүйл бол үндэстний тусгаар тогтнолын хувьсгал гарах урьдач нөхцөл бүрэлдэж ирснийг Өвөр Монголын нийгэм ахуйн талаас нягталж үзжээ. Нөгөө талаар Халх Монгол дахь улс төрийн хандлага өөрөөр хэлбэл Жавзандамба хутагтын үзэл сэтгэлгээний хувиралтын байдлыг хэрхэвч бодолхийлэх үгүй байж болохгүй. Учир нь Чин улсын сүүлчээр Далай лам Халх Монголд цагаачилсан ба тэр цагийн Далай ламын учирал нь Жавзандамба хутагт лугаа их цочоо сануулга болж түүний Чин улсаас салж тусгаар тогтнох улс төрийн бодлогыг үүсгэсэн юм.

1911 онд Богд хааны засгийн газрын байгуулагдсан тухай лавшруулан яривал мөн оны 11-р сарын эхээр Их Хүрээнд Монголын түр засгийн газар байгуулагдаад мөн сарын 29-ны өдөр Чин улсын Монголд суугаа сайд Сандод хандан “.....монголчууд бүх газар орноо бүрэн эрхт Их Монгол улсыг байгуулж Богд Жавзандамбыг хаан болгон өргөмжлөхөөр тогтжээ” гэж тунхагласан бөгөөд сайд ба түшмэд цэргүүдийг “гурван хоногийн дотор хязгаараас гаргатугай. Зөрчвөөс цэргийн хүч хэрэглэж уул нутагт нь хүргэмой хэмээжүхүй” гэсэн Жавзандамба хутагтын зарлигыг уламжлав. Энэ мэтээр Монголын түр засгийн газраас Чин улсын сайдууд яамыг устгаж Монголд суугаа сайдыг хасаж хятад цэргийн зэвсгийг хураасны дараа Монгол өөртөө тусгаар улс болон тогтносон тухай Богд Жавзандамбын зарлиг тушаал зэргийг дурьдаж Өвөр Монголын хошуу чуулган ба бусад Хөлөнбуйр, Дарьганга, Алшаа зэрэг монгол газруудад элч бичгийг явуулахын дагуу цэргийн явдлыг шалавлан хийжээ.

Мөн засгийн газраас Богд гэгээнийг Монгол улсын хаанд өргөмжлөн эрдэнийн сууринд суулгах ёслолыг 1911 оны 10-р сарын 16-ны өдрийн 11 цагт гүйцэтгэсэн бөгөөд “Богд хаанаас засгийн газрыг байгуулахдаа дотоод, гадаад, цэрэг, сан, шүүх хэмээх таван яам байгуулж Дотоод яамны тэргүүн сайдад Да лам Цэрэнчимэд, дэд сайдад Далай чойнхор ван Цэдэнсодном, Сэцэн ван Гомбосүрэн, дэс түшмэлд гүн Хайшаа, баатар гүн Лхам, Магсаржав, Гадаад яамны тэргүүн сайдад Чин ван Ханддорж, дэд сайдад их шавь Да лам Равдан, жич дагаар ирж гүнгийн шагнагдсан баргын занги Дамдинсүрэн, дэс түшмэлд зайсан Цэрэндорж, тойн лам Лувсанжамбаа, Цэргийн яамны тэргүүн сайдад Эрдэнэ далай ван Гомбосүрэн, дэд сайдад зоригт бээс Агваандорж, баатар бээс Базарваань, дэс түшмэлд гүн Содномдорж, захирагч Гунгаадонь, Сангийн яамны тэргүүн сайдад түшээт хан Шагдаржав, дэд сайдад бишрэлт ван Доржцэрэн, сартуул сэцэн бээс Жалцангомбоцэдэн, дэс түшмэлд зайсан лам Лувсанбалдан, түшмэл Нарийнваанчиг, Шүүх яамны тэргүүн сайдад эрдэнэ ван Намсрай, дэд сайдад ачит бээс Сансрайдорж, мэргэн бэйс Дугаржав, дэс түшмэлд Туваанжав, баргын түшмэл Гайхас нарыг сонгож бус олон ноёд лам нар нижгээд зэрэг хэргэм дэвшүүлж заларсан” байна.

Мөн энэ үед Богд хааны засгийн газраас Бээжингийн дотоод яам, засагт тус гэх яаман, гадаад хэргийн журган нэр хамталж цахилгаан мэдээ явуулсан байна. Цахилгаан мэдээндээ “түмэн зүйлийн арга үгүйгээс үүдэж алтан ордны зүг хандаж тэнгэрийн гэгээнээс хагашахын ёсоор мөргөөд бүгдээр Богдыг өргөмжлөн эзэн болгож, улсын цолыг Монгол хэмээн уламжлан умар зүгийн дэлхийдээ орон газрыг уул эзэн нь хураан авч бүрэн бүтэн болгон батлав. Үүнээс тус тус зах хязгаарыг сахиж эрх үгүй ёслол найрлалыг урьтал болгон дараа өмнөд муж тогтсон цаг дор харин ч гэрээ бичгийг хэлэлцэн холбоог дуусгаваас болмой. Тэнгэрийн ёсонд өгүүлэхээр хамаг бодис зөвшин эвдэрснийг эрх үгүй мэдэх хэрэгтэй. Засагт ном дор өгүүлсэн нь тэнгэрийн бошго ашид үгүй гагцхүү эрдэмтэй нь сая хүлээж болмой хэмээжээ” гэж тусгаар тогтносон учраа илтгэн мэдэгдэхийн хамт дотор газар байдал тогтворжсоны хойно хөрш орны харилцаа тогтоох саналаа илэрхийлсэн байна.

Богд хааны засгийн газар нь Ар, Өвөр Монголыг багтаасан “тусгаар тогтносон Монгол улс”-ыг байгуулахаар зорилгоо болгож Өвөр Монголын эл газарт элч томилон “Монголыг нэгтгэх” зарлигаа уламжилжээ. Энэ үед иргэн улсын засгийн газар нь идэвхтэй арга хэмжээ авч өвөр чуулганы монгол хошуудын улс төрд хүчтэй нөлөөлж байжээ. Богд хааны засгийн газар бүрэлдэн тогтносон тэр цагаасаа Өвөр Монголын зүг цэрэглэх явдлыг төрийн чиглэл болгосон байжээ. Тэр үед Жавзандамба хутагт олон өвөр монголчуудыг хүлээн авч байсан нь үүнтэй холбоотой юм. Дээр дурьдсан Өвөр Монголд болсон үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний удирдагчдын

дотор Гүнсэन्नоровоос бусад нь цөм Богд хааны засгийн газарт оролцож, чухал чухал тушаалд томилогдсон байна. Мөн эдгээр хүмүүс Богд хааны засгийн газрын өмнөөс цэрэг дайчлан 1913 оны Өвөр Монголын дайныг үүсгэжээ. 1912 онд хагас жил эсэргүүцэгдэж бүхий хоёр этгээдийн хооронд зэвсэгт мөргөлдөөн тасралтгүй сөргөж 1913 оны эхээр Богд хааны засгийн газрын цэрэг таван зам хуваан Өвөр Монголын зүг бүх талаар дайран тэнд суугаа иргэн улсын цэрэгтэй байлдав. Богд хааны цэрэг нь зэвсэгт хүчнээр Өвөрмонголыг эзлэн авч улс төрийн хил хязгаарыг тогтоох гэсэн зорилготой байжээ.

Хоёр этгээдийн цэрэг олон удаа ширүүн тулалдаж 1913 оны 9-р сар болоход монгол цэрэг Өвөр Монголын ихэнх хэсэг газрыг эзлэн авч 1913 оны сүүлчээр монгол цэрэг эзэлсэн нутаг дэвсгэрээ дахин алдаж эхэлсэн юм. Бүтэн жил шахам үргэлжилсэн Өвөр Монголын байлдаан нь эцэстээ Хаант Орос улс хэлэлцээнд оролцсоноос Богд хааны засгийн газар Өвөр Монголын нутагт байлдан буй цэргээ гэдрэг татан Халхын хил дотор авчрав. Гэвч Бээжингийн засгийн газар нь Өвөр Монголоос цэргээ татсангүй. Давуу хүчийг олсон иргэн улсын цэрэг Өвөр Монголд алага хядлагаа үргэлжлүүлж байжээ. Энэ үед Богд хааны засгийн газар нь гадаад харилцааны шугамаар Өвөр Монголын асуудлыг шийдвэрлэх бодлого явуулж, Орос, Хятад, Монгол гурван этгээдийн хэлэлцээрт оролцох болжээ. Тус хэлэлцээрийн үр дүнд Ар, Өвөр Монголыг тасдан хувааж Өвөр Монгол нь иргэн улсын харъяат болов. Энэ нь яриан үгүй Монголын хувьд нэг их доржилт болжээ. Гурван этгээдийн хэлэлцээрийн тогтоолд эсэргүүцэн боссон Бавуужавын цэрэг анги Өвөр Монголд байгаа иргэн улсын цэрэгтэй дахин тулалдаж эхлэн их, бага байлдааныг хийсээр эцэстээ 1916 онд ялагдсан байна.

1913 оноос өргөжин явагдсан энэ удаагийн байлдаан нь бүх Өвөр Монголыг хамарч олон хошуу чуулганд маш их нөлөө тусгал болж үндэстний зөрчил улмаар ширүүссэн. Өвөр Монголын улс төрийн дэглэм бүрмөсөн самуурч ар, өвөр хоёр талаас болсон улс төрийн хүчний хооронд хавчигдсан Өвөр Монголын нийгмийн хүнд хэцүү байдал буй болжээ.

Тус өгүүлэлд Богд хааны засгийн газар болон 1913 онд болсон Өвөр Монголын байлдааны харьцаа холбоо хэмээх том асуудлыг цогцоор нь авч үзжээ. Ийнхүү бүхэллэг асуудлыг цаашид жижиг жижиг болгон нарийвчлан судлах хэрэгтэй. Тухайлбал Богд хааны засгийн газар ба иргэн улсын засгийн газрын хооронд болсон зууралдааны үндэс сурвалж, зэвсэгт мөргөлдөөн үүссэн шалтгаан жич 1913 оны байлдааны бүх явц гэх зэрэг холбогдох олон асуудлуудыг шат хуваан жижиглэн нягтлал хийж боловсруулан бичих нь чухалтай юм.